



**ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН**

**Аудитын нэр: САНТ СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**

**Аудитад хамрагдсан жил: 2024 эхний хагас жил**

**АУДИТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГА: СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА**

**АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА: “САНТ СУМЫН ТТЗ”**

**АУДИТ ХИЙГДСЭН ОБЪЕКТ: “САНТ СУМЫН ТТЗ”**

**АУДИТЫН ТӨРӨЛ: ГҮЙЦЭТГЭЛИЙН**

**АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА: 2024.07.22-2024.08.16**

**АУДИТАД ХАМРАГДСАН ХУГАЦАА: 2024**

**Тайланг бэлтгэсэн:**

**Дотоод аудитын нэгжийн  
удирдлагын дарга**

Сэлэнгэ аймгийн Засаг даргын  
дэргэдэх Санхүүгийн хяналт,  
дотоод аудитын албаны дарга,  
СХШУАБ Т.Одсүрэн

**Аудитын багийн ахлагч :**

Ахлах дотоод аудитор,  
СХШУБ Т.Мөнхзул

**Аудитын багийн гишүүн:**

Дотоод аудитор Х.Батбаатар,

Огноо:2024 оны 08 дугаар  
сарын 09 өдөр

Сүхбаатар сумын 2 дугаар баг.  
Нутгийн удирдлагын II байр  
sankhuu\_audit\_se@yahoo.com

**1. ТАНИЛЦУУЛГА**

**2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ,**

**2.1.Аудитын зорилго**

**2.2 Аудитын цар хүрээ**

**2.3.Аудитын арга аргачлал, хязгаарлалт**

**3.БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА**

**3.1 Засаглалын талаар**

**3.2 Эрсдэлийн удирдлагын талаар**

**3.3 Дотоод хяналтын талаар**

**4.АУДИТЫН ҮР ДҮН**

**4.1 Илэрсэн асуудлууд**

**5.НЭГДСЭН ДҮГНЭЛТ**

## 1. ТАНИЛЦУУЛГА

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, 14.2.10, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, “Дүрэм батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, Дотоод аудитын хорооны 2024 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг аймгийн Засаг дарга бөгөөд Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн 2024 оны 07 дугаар сарын 8-ны өдрийн 06 дугаар удирдамжийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Сант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд дотоод аудитыг хийж гүйцэтгэлээ.

Дотоод аудитыг Засгийн газрын 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийг тус тус үндэслэн санхүүгийн хяналт шалгалт, эрх зүйн нийцлийн чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ба 2024 оны эхний хагас жилийн үйл явцыг хамруулан, дахин тооцоолох, тулган шалгах хяналтын горимыг ашиглах, холбогдох ажилтнуудтай ярилцах, дотоод хяналтын орчныг судлах, үнэлэх, ажил гүйлгээг батлах, хянах, бүртгэх, тайлагнах процессын эрсдэлийг үнэлэх, мөрдвөл зохих хууль тогтоомжийн зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн байдлыг бодитоор илэрхийлж тогтоох, зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдсөн байдал, практикт нийцэж байгаа байдлыг шалгуур үзүүлэлтээр тодорхойлж ажиллав.

## 2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

### 2.1 Аудитын зорилго:

Сант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой.

### 2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Сант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн удирдлага зохион байгуулалтын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцыг үнэлэх;

Аудитаар тус газрын 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг хамруулна.

Үүнд:

- ❖ *Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцыг үнэлэх;*
- ❖ *Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт,*
- ❖ *Засаг даргын Тамгын газрын хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалт, томилголоо, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт*
- ❖ *Засгийн газрын тогтоол шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн*

*захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт.*

- ❖ *Аж ахуйн нэгж байгууллага, иргэнтэй байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт.*
- ❖ *Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт тавих*
- ❖ *Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт үр дүн*
- ❖ *Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт*

### **Аудитын хамрах хүрээний хязгаарлалт:**

Сант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны үйл ажиллагааны хамрах хүрээнд хязгаарлалт байхгүй болно.

### **2.3 Аудитын арга, аргачлал**

Дотоод аудитын мэргэжлийн практикийн Олон улсын стандарт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Монгол улсын сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 268 дугаар тушаалаар батлагдсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ын дагуу үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэн албан тушаалтнаас асуулга тодруулга авах, нотлох зүйлсийг нягтлах, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх горимуудыг ашиглав.

### **2.4. Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:**

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, журам, дүрэм, зааврыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Авлигын эсрэг хууль
- Төсвийн тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам
- Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам
- Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам
- СТОУС, НББОУС болон бусад стандартууд
- Бусад хууль, эрх зүйн актууд

## **2.5 Аудитын хугацаа, бүрэлдэхүүн**

Дотоод аудитыг 2024 оны 07 дугаар сарын 22-ны өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 09-ний өдрийг хүртэлх хугацаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны ахлах дотоод аудитор (Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч) Т.Мөнхзул хянан удирдаж, дотоод аудитор Х.Батбаатар гүйцэтгэв.

## **3. Байгууллагын сайн туршлага**

Сумын удирдлагын баг болоод төрийн албан хаагч нар тогтвор суурьшилтай ажилладаг тул төрийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахад ямар нэгэн саад бэрхшээл тулгардаггүй болно. Мөн Сант сум нь аймгийн төв болоод Улаанбаатар хоттой хатуу хучилттай замаар холбогдсон сүүлийн жилүүдэд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл усалгаатай газар тариаланг түлхүү хөгжүүлж байна. Мах сүүний чиглэлийн Сэлэнгэ буюу казахын цагаан толгойт үүлдрийн үхрийн цөм сүргийг тухай бүс нутагт өсгөн үржүүлж байна.

### **3.1 Засаглалын талаар**

Сэлэнгэ аймгийн Сант сумын удирдлагын баг нь тогтвор суурьшилтай ажиллаж байна. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Л.Аврага 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс өнөөдрийг хүртэл, сумын Засаг дарга С.Шижирбаатар нь 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс өнөөдрийн хүртэл, Засаг даргын орлогч Б.Мөнх-Эрдэнэ 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс өнөөдрийн хүртэл, Ивэн 1 дүгээр багийн Засаг даргаар Л.Сэлэнгэсайхан 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс өнөөдрийг хүртэл, Хушаат 2 дугаар багийн Засаг даргаар Б.Золбаяр 2017 оны 05 дүгээр сарын 01-ний өдрөөс өнөөдрийг хүртэл, сумын Засаг даргын Тамгын газрын дарга А.Одхүү 2014 оны дүгээр 01 дүгээр сарын 08-ны өдрөөс өнөөдрийг хүртэл, Сумын төсвийн ерөнхий нягтлан бодогч Б.Ууганцэцэг 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс өнөөдрийг хүртэл тус тус ажиллаж байна.

### **3.2 Эрсдэлийн удирдлагын талаар**

Тус сум нь эрсдэлийн удирдлагын бодлого, журам боловсруулаагүй, эрсдэлийн бүртгэл хөтлөөгүй байна. Байгууллагын эрсдэлийн үйл явцыг үнэлэхэд хүлээн зөвшөөрөх эрсдэл, эрсдэлийн мэдээллийг ашиглах зэрэг үнэлэх шалгууруудын түвшин бүрд байгууллагын эрсдэлийн удирдлагыг тодорхойлж үнэлээгүй байна.

Удирдлагын “ёс зүйтэй байдлыг дэмжин урамшуулах байдал”, ёс зүйгүй үйлдлийн эсрэг хандах хандлага, авах арга хэмжээ буруу, удирдлага шаардлага тавьсан ч үе шатны хяналтыг дутуу орхигдуулснаас хэрэгжилт нь хангалтгүй.

Байгууллагын эрсдэлийн удирдлагын төлөвшлийг тодорхойлоход эрсдэлийн соёл, эрсдэлийн засаглал, эрсдэлийн үйл явц эхлэлийн буюу 2-р түвшинд байна.

Иймд Сант сумын Засаг даргад байгууллагын эрсдэлийг тодорхойлж, төлөвлөгөө боловсруулан, биелэлтийг цаг тухай бүрд тайлагнан хариу арга хэмжээ авч ажиллахыг зөвлөж байна.

### 3.3 Дотоод хяналтын системийн талаар

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг Зохион байгуулах нийтлэг журам”, байна гэж тусгасан боловч дотоод хяналтын ажилтан томилон ажиллуулаагүй байна.

Иймд Сант сумын Засаг даргад байгууллагын дотоод хяналтын ажилтан томилон ажиллуулах, эс бөгөөс дотоод нөөц бололцоондоо тулгуурлан бусдаар хавсран гүйцэтгүүлэхийг зөвлөж байна.

## 4. АУДИТЫН ҮР ДҮН

<b><u>Илэрсэн асуудал 1</u></b>	Эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын бодлого журамгүй.
<b><u>Асуудлын ангилал</u></b>	Нөлөө дунд
<b>Бодит байдал:</b> Улирал бүр дотоод хяналтыг зохион байгуулдаг боловч бодлого журам боловсруулаагүй.	
<b>Байх ёстой шаардлага /шалгуур/:</b> Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 3.4. Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны онцлог, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, хэмжээ, зохион байгуулалтын бүтэц, харьяалагдах нэгж, объектын тоог харгалзан тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөж ажиллана.	
<b>Асуудлын үндсэн шалтгаан:</b> Эрсдэлийн үнэлгээний ерөнхий ойлголт, ач холбогдол, үнэлгээ хийх арга аргачлалын талаар холбогдох албан тушаалтанг томилон сургалтад хамруулдаггүй.	
<b>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:</b> Эрсдэлээ тодорхойлоогүй нөхцөлд байгууллага зорилгодоо хүрэхэд хүндрэлтэй. Төсөв санхүүгийн хүндрэл бэрхшээл тулгарах цаашид хэвийн үйл ажиллагаа алдагдах	
<b>Шийдвэр:</b> Дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагын бодлого журамтай болох <b>зөвлөмж</b> хүргүүлэхээр шийдвэрлэв.	

<b><u>Илэрсэн асуудал 2</u></b>	Төрийн албан хаагчийн улирлын үр дүнгийн үнэлгээг журмын дагуу үнэлээгүй
<b><u>Асуудлын ангилал</u></b>	Нөлөө дунд
<b>Бодит байдал:</b> Сант сумын Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны албан хаагчдын эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний хуудсанд тухайн төрийн албан хаагчийн өөрийн үнэлгээг үнэлгээний баг дахин үнэлж баталгаажуулаагүй.	
<b>Байх ёстой шаардлага /шалгуур/:</b> Засгийн газрын 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоолын хавсралт, “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 6.1.Төсвийн шууд захирагчийн шийдвэрээр албан хаагчдын төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх, хянаж баталгаажуулах, мэдээлэх чиг үүрэг бүхий удирдах албан тушаалтан болон төрийн жинхэнэ албан хаагчийн төлөөллөөс бүрдсэн Үнэлгээний багийг жилд нэг удаа 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор байгуулна. Тухайн байгууллага зохион байгуулалтын нэгжгүй, эсвэл 15 хүртэлх тооны албан хаагчтай бол үнэлгээний баг байгуулахгүй бөгөөд үнэлгээний багийн үүргийг төсвийн шууд захирагч гүйцэтгэнэ.	
<b>Асуудлын үндсэн шалтгаан:</b> Сумын Засаг даргын Тамгын газар нь 15 дээш албан хаагчтай тул үнэлгээний багийг байгуулаагүй нь журмын хэрэгжилтийг хангаагүй байна.	
<b>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:</b> Үнэлгээний багийг байгуулж журмын дагуу албан хаагчийн үнэлгээг баталгаажуулаагүйн улмаас маргаан үүсэх эрсдэлтэй байна.	
<b>Шийдвэр:</b> Цаашид үнэлгээний багийг байгуулж журмын дагуу төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх <b>зөвлөмж</b> хүргүүлэхээр шийдвэрлэв.	

<b><u>Илэрсэн асуудал 3</u></b>	ХХС-н 2024 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн бараа материалын тодруулга тайланд шатахуун, бичиг хэргийн материал нийт 299,960.0 төгрөгийн худалдан авалт, зарцуулалтыг тусгаагүй.
<b><u>Асуудлын ангилал</u></b>	Нөлөө их
<b>Бодит байдал:</b> ХХС-н данснаас 148,000.0 төгрөгийн бичиг хэргийн материал, 151,960.0 төгрөгийн шатахууны зарлагын гүйлгээ хийсэн бөгөөд худалдан авсан бичиг хэргийн материал, шатахууныг бараа материалын бүртгэлд тусгаагүй мөн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн бараа материалын тодруулга тайланд худалдан авалт, зарцуулалтыг тусгаагүй байна.	
<b>Байх ёстой шаардлага /шалгуур/:</b> Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дахь “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална.”, 5.1.4 үнэн	

<p>зөв байх, 8 дугаар зүйлийн 8.4 дэх дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна. Санхүүгийн тайланг цахим хэлбэрээр гаргах тохиолдолд цахим гарын үсэг хэрэглэж баталгаажуулна.....” гэсэн заалттай нийцэхгүй байна.</p>
<p><b>Асуудлын үндсэн шалтгаан:</b> Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бодлогын баримт бичиг болон холбогдох дүрэм журмаа мөрдөж ажиллаагүй. Санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллаагүй. Байгууллагын нягтланг бодох бүртгэлд тавих хяналт сул.</p>
<p><b>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:</b> Санхүүгийн үр дүн буруу илэрхийлэгдэж тайлан мэдээ алдаатай мэдээлэгдэнэ.</p>
<p><b>Шийдвэр:</b> Цаашид Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бодлогын баримт бичиг болон холбогдох дүрэм журмаа мөрдөж санхүүгийн тайлан мэдээг үнэн зөв бүртгэх <b>албан шаардлага</b> хүргүүлэхээр шийдвэрлэв.</p>

<b><u>Илэрсэн асуудал 4</u></b>	ОНХС-н 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн бараа материалын тодруулга тайланд шатахууны худалдан авалт, зарцуулалтыг тусгаагүй.
<b><u>Асуудлын ангилал</u></b>	Нөлөө их
<b>Бодит байдал:</b>	ОНХС-н данснаас 993,400.0 төгрөгийн шатахууны зарлагын гүйлгээ хийсэн бөгөөд худалдан авсан шатахууныг бараа материалын бүртгэлд тусгаагүй мөн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн бараа материалын тодруулга тайланд худалдан авалт, зарцуулалтыг тусгаагүй байна.
<b>Байх ёстой шаардлага /шалгуур/:</b>	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дахь “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална.”, 5.1.4 үнэн зөв байх, 8 дугаар зүйлийн 8.4 дэх дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна. Санхүүгийн тайланг цахим хэлбэрээр гаргах тохиолдолд цахим гарын үсэг хэрэглэж баталгаажуулна.....” гэсэн заалттай нийцэхгүй байна.
<b>Асуудлын үндсэн шалтгаан:</b>	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бодлогын баримт бичиг болон холбогдох дүрэм журмаа мөрдөж ажиллаагүй. Санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллаагүй. Байгууллагын нягтланг бодох бүртгэлд тавих хяналт сул.
<b>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:</b>	Санхүүгийн үр дүн буруу илэрхийлэгдэж тайлан мэдээ алдаатай мэдээлэгдэнэ.

**Шийдвэр:**

Цаашид Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бодлогын баримт бичиг болон холбогдох дүрэм журмаа мөрдөж санхүүгийн тайлан мэдээг үнэн зөв бүртгэх **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

<b><u>Илэрсэн асуудал 5</u></b>	ОНХС дээр шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй.
<b><u>Асуудлын ангилал</u></b>	Нөлөө дунд
<b>Бодит байдал:</b> ОНХС дээр шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж мэдээ мэдээллийг байршуулаагүй.	
<b>Байх ёстой шаардлага /шалгуур/:</b> Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор; 6.2.1 эрх бүхий байгууллагаас баталсан жилийн төсөв, гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт, 6.2.1 орлого /үндсэн үйл ажиллагааны орлого, төсөвт байгууллагын өөрийн орлого/, 6.2.3 урсгал зардал /цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, бусад урсгал зардал, хөрөнгийн зардал, татаас шилжүүлэг/, 6.2.4 хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, төр, хувийн хэвшлийн түншлэлийн жагсаалт.	
<b>Асуудлын үндсэн шалтгаан:</b> Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаагүй. Санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллаагүй.	
<b>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:</b> Хуулийн хэрэгжилтийг хангаагүйн улмаас байгууллагын үнэлэлт дүгнэлтэд сөргөөр нөлөөлж ил тод байдал алдагдах.	
<b>Шийдвэр:</b> Цаашид шилэн дансны тухай хэрэгжилтийг ханган ажиллах <b>зөвлөмж</b> хүргүүлэхээр шийдвэрлэв.	

<b><u>Илэрсэн асуудал 6</u></b>	ОНХС-ын данснаас анхан шатны баримтын бүртгэлгүй ажил гүйлгээг бүртгэж зардал гаргасан. /Малчдын зөвлөгөөнд 1,644,500.0, вакцинжуулалтын шатахууны зардал 993,400.0/
<b><u>Асуудлын ангилал</u></b>	Нөлөө их
<b>Бодит байдал:</b> Орон нутгийн хөгжлийн сангаас Малчдад зориулсан сургалт зохион байгуулсан боловч сургалтад оролцогчдын бүртгэлгүй, сургалт зохион байгуулсан тайлан танилцуулга байхгүй. Мөн малчдын сургалт сурталчилгаа, вакцинжуулалтын шатахууны зардал гаргасан боловч маршрут, шатахуун хүссэн шаардах хуудас, зарцуулсан замын хуудас байхгүй.	

<b>Байх ёстой шаардлага /шалгуур/:</b>
Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, гэсэн заалттай нийцэхгүй байна.
<b>Асуудлын үндсэн шалтгаан:</b>
Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бодлогын баримт бичиг болон холбогдох дүрэм журмаа мөрдөж ажиллаагүй. Байгууллагын нягтлагч бодох бүртгэлд тавих хяналт сул.
<b>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:</b>
Төсөвт үр ашиггүй зардал үүсэх, хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилт хангагдахгүй байх.
<b>Шийдвэр:</b>
Цаашид анхан шатны баримтын бүртгэлгүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх. Анхан шатны баримтын бүрдэлгүй 2,637,900.0 төгрөгийн зөрчилд <b>албан шаардлага</b> хүргүүлэхээр шийдвэрлэв.

### 5.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Сант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу дотоод аудитыг хийж гүйцэтгэхэд илэрсэн алдаа зөрчлийг үндэслэн “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлтийг өгч байна.

Байгууллага өөрийн зорилгодоо хүрэхийн тулд ажил хэргээ арвич хямгач, үр дүнтэй эрхлэн явуулахад сайн зохион байгуулагдсан хяналтын тогтолцоо хэрэгтэй гэдгийг удирдлага ойлгон түүнийг хэрэглэх механизмаа бүрдүүлэх, шийдвэр гаргалтад түүний үр нөлөөг ашиглаж чаддаг байх нь чухал.

Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
Сайжруулах шаардлагатай	Засаглал эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь “эхлэлийн буюу 2-р түвшин”-д байна гэж үзсэн. Аудитаар илэрсэн асуудлуудын 50 хувь нь “нөлөө ихтэй” гэж үзсэн.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:  
ДОТООД АУДИТОР

Х.БАТБААТАР

ТАЙЛАН ХЯНАСАН:  
АХЛАХ ДОТООД АУДИТОР

МӨНХЗУЛ

ТАНИЛЦСАН:

САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА

С.ШИЖИРБААТАР

ТӨСВИЙН ЕРӨНХИЙ  
НЯГТЛАН БОДОГЧ

Г.УУГАНЦЭЦЭГ

НЯГТЛАН БОДОГЧ:

Ч.МӨНХЗАЯА